

Монголын хэвлэл мэдээлэл хэний гарт байна вэ?

Сэтгүүлч Б.Галаарид

Мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяаллын асуудал өнөөдөр эрдэмтэн судлаачдын анхаарлыг ихээхэн татаж байна. Эзэмшлийн асуудал нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдал, редакцийн хараат бус байдалд ихээхэн нөлөөтэй бөгөөд эцэстээ мэдээлэл олж авах, түгээх эрхээ иргэд бүрэн эдэлж чадах орчин бий болсон эсэхийг тодорхойлогч хүчин зүйлийн нэг болж өгдөг.

Монголд хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн хэд хэдэн үе шат тодорхой ажиглагддаг. Социалист чиг баримжаагаар хөгжиж байсан үе буюу 1990 оноос өмнө мөн чанартаа мэдээллийн бүх хэрэгсэл төрийн мэдэлд байлаа. Хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд, спорт гэх мэт өөрийгөө санхүүжүүлэгч салбарын хэвлэлүүд байсан ч үзэл суртлын хяналтын нэгдмэл тогтолцоон дор үйл ажиллагаагаа явуулж байсан болохоор хэрэг дээрээ нам төвтэй төрийн эзэмшлийнх байлаа.

1990 оноос анхны хувийн хэвлэлүүд бий болсноор эзэмшлийн олон хэлбэр бүхий тогтолцоо бий боллоо. Тооны хувьд 1990 оноос хойш хувийн эзэмшлийн ХМХ илт давамгайлж ирсэн бөгөөд энэ байдал одоо ч хэвээр байна. Гэхдээ хугацааны эхэнд төрийн мэдлийн сонин, ТВ, радио хүртээмж, тараалт түгээлт, захиалгаар давамгайлж, төрөөс үүнийг нь бүх талаар хөхиүлэн, шинээр өөрийн мэдлийн ХМХ бий болгох зэргээр дэмжиж, хувийн хэвшлийнхэн гарааны тэгш бус байдлын зөрүүг хурцаар мэдэрч байв. Өнөөдөр энэ байдал ихээхэн хязгаарлагдсан бөгөөд төр шууд удирдах бус, эдийн засгийн болон улс төрийн аргаар дам нөлөөлөх хэлбэр рүү үндсэндээ шилжээд байна.

ХМХ-ийн эзэмшигч нь хувь хүн, хуулийн этгээд, хэсэг бүлэг хүн байх хэлбэр давамгайлж байгаа өнөөдрийн байдлыг хувийн эзэмшил давамгайлсан үе гэж томъёолж болно. Мөн МҮРТВ олон нийтийнх болж, эзэмшил харьяаллын цоо шинэ хэлбэр бий болоод байна. Энэ бол соц-ын үед оршин тогтнож байсан эрх мэдлийн монополийг задалж чадсаны илрэл. ХМХ-ийн эзэмшлийн энэхүү олон хэлбэрт байдал нь үзэл бодлын зах зээлд урьд өмнө нь байгаагүй олон янзын дуу хоолойг оруулж ирснээрээ шинэчлэгч чанарыг агуулж байгаа юм. Гэхдээ энэхүү мэдээллийн зах зээлийг хэрхэн нээлттэй байлгах вэ, хэнд хүртээмжтэй байлгах вэ, энэ зах зээлд шинээр мэдээлэл, үзэл бодол нийлүүлэгч, байр сууриа илэрхийлэгч нь хэн бэ гэдэг асуудлыг анхаарах учиртай. Өөрөөр хэлбэл шинээр гарч ирж буй ХМХ улстөр бизнесийн ямар нэг бүлэглэлээс ил ба далд, шууд ба дам ямар нэг хэлбэрээр санхүүжиж, тэдний тодорхой зорилгыг илэрхийлэгч болж байгаа эсэхийг анхаарах ёстой.

Нийгмийн хөрөнгө эрх мэдэлтэй хэсэг, бүлэглэлүүд хувь сэтгүүлч, тодорхой ХМХ-ийг өөрийн мэдэлд байлгахыг ямагт эрмэлздэгээс гадна өөрийн гэсэн ХМХ-ийн цогцтой болохоор оролдох нь нийгмийн шилжилт, шинэчлэл хийж буй зарим оронд анзаарагдаж буй үзэгдэл юм. Энэ үзэгдэл Монголд ч анзаарагдаж байна. Иргэн хүн хэн боловч ХМХ үүсгэн байгуулах эрхтэй гэдгээр тэднийг зөвтгөж болох ч улстөрийн тодорхой зорилгоор ХМ-ийн цогц байгуулж, монополь үүсгэхийг оролдож байвал

туйлын аюултай. Сүүлийн үед Монголын улстөрчид ихээхэн “хэвлэл мэдээлэлжиж” эхэллээ. Манайх бол өдөр тутмын 2-3 сонин, мөн тооны телевиз л агуулах багтаамжтай зах зээл билээ. Ийм жижигхэн зах зээл дээр өдөр тутмын 14 сонин, хорь шахам телевиз оршин тогтноод байгаа нь зах зээлийн хуулиас гажууд бөгөөд энэ үзэгдлийн учир шалтгааныг улстөр-бизнесийн тодорхой бүлэглэлээс эрэхээс аргагүй болчихоод байна. ХМ-ийн олон хэрэгслийн цаана улстөрчид байгаа ч МУ-ын Ерөнхийлөгч Н.Энхбаяр нэг удаагийн ярилцлагадаа ТВ-9-д хувь эзэмшдэгээ олон нийтэд зарласнаас өөрөөр хэн нэгэн улстөрч үнэнээ мэдээлэлгүй өнөөдрийг хүрлээ. Гэтэл Ц.Элбэгдорж “Оллоо” сайтыг худалдан авсан, улстөрч Х.Баттулга С-1 ТВ, “Ардчилал”, “Монголын мэдээ” сонины эзэн гэх мэт яриа олны дунд хэсүүчилсээр байна. Улстөрч Ц.Мөнх-Оргил, З.Энхболд гээд ямар нэгэн ХМХ-тэй нэр холбогдсон улстөрчдийн тоо нэлээд олон болоод байна. Энэ бүгд үнэн ч бай, худал ч бай хэт нэг талыг барьсан, хэн нэгнийг илэрхий өмгөөлсөн туйлширмал, талцсан байдал олон ХМХ-д анзаарагдаж байгаа нь ХМХ-ийн эзэмшлийн ил тод байдлын асуудлыг сөхөн тавихад хүргэж байна. ХМХ-ийн эзэмшигч нь улстөр бизнесийн томоохон бүлэглэлийн төлөөлөл байх, эсвэл ХМХ-ийн эзэд улстөрд орох нь хуулиар хориглоогүй эрх хэдий ч энэ нь ардчилсан сэтгүүлзүйн үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Мөн нөлөө бүхий улстөрчид нөлөө бүхий ХМХ-тэй сүжрэх үзэгдэл элбэг байгаа нь ч сөргөөр нөлөөлж байна. Энэ бол дан ганц хувийн хэвшилд тулгуурласан ХМХ-ийн тогтолцоо давамгайлахын сул талын илэрхийлэл юм.

Ийм зохисгүй байдлаас гарах гарц нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийг дэмжих явдал гэсэн дуу хоолой сүүлийн үед манайд нэлээд хүчтэй байна. Гэхдээ олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дангаар ноёрхогч орны тоо сүүлийн үед бас буурч, хувийн мэдээллийн хэрэгсэлтэй хоршсон орны тоо нэмэгдэж байгаа чиг хандлагыг анхааралдаа авч, энэхүү холимог тогтолцоог сайжруулах, боловсронгуй болгох асуудлыг авч үзэх нь зүйтэй санагдана. Үүний тулд эн тэргүүнд хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийг ил тод болгох, эзэмшигчийн эрх үүргийн хязгаарлалтыг хуульчлах, редакцийн хараат бус байдлыг баталгаажуулах асуудал хурцаар тавигдаж байна.

Эзний шууд ба дам цагдан хяналт бүхий ХМХ нь олон ургальч үзлийг бүхэлд нь боомилдгүйгээрээ ихээхэн эрх чөлөөтэй мэт харагдавч тодорхой нөхцөлд мэдээллийг хааж хянадаг. Цөөн тооны эзэмшигчид мэдээллийг хянаж, өөрийн эрх ашигт нийцэх өнцгөөс цацах төдийгүй эрх баригчидтай улс төр, бизнесийн сүлжээнд нэгдэж, иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хумих нь бусад салбартай харьцуулбал ардчилалд учруулах сөрөг үр дагаврын хувьд зүйрлэшгүй их гэдгийг анхаарч, хараат бус хэвлэл мэдээлэл хөгжих хууль эрх зүйн орчин бүрдүүлж, түүнийгээ дагаж мөрдөж чадах юм бол ХМХ-ийн эзэмшлийн асуудал өнөөгийнх шиг хурцаар тавигдахгүй билээ.

**“ХІХ зүйл ба эрх зүйн орчин” дугуй ширээний ярилцлага
2008.12.08**